

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2015 оны 06 сарын мэдээ

Удирдлага зохион байгуулалт

Захиргааны ажилчин, албан хаагчид өөрсдийн хүчээр байгууллагын хашаанд явган гүүр барьж тохижууллаа.



Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Үүртийн тохойн байгаль хамгаалагчийн ажлын байрыг НҮБ-ын ТХГНСБэхжүүлэх нь төслийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд орууллаа.



Тус барилгын ажлыг Өвөрхангай аймгийн Өглөөн наран ХХК гүйцэтгэсэн бөгөөд ТХГНутагт нэвтрэх хаалга, олон нийтийн бие засах газрыг хамт гүйцэтгэсэн юм.

Барилгын ажлын явцад мэргэжлийн баг гарч 2 удаа хяналт үнэлгээ хийж ажилласан.

Япон улсаас олон улсад хэрэгжүүлдэг Жайка төслийн судалгааны багийн төлөвлөлтийн зөвлөх Аяако Накагава, төслийн ажилтан Ц.Буянжаргал нар хамгаалалтын захиргааны дарга Г.Эрдэнэбилэг, мэргэжилтэн Ч. Суурьтогтох нартай уулзан цогцолборт газрын хамгаалалын менежмент, аялагчдын тоо, хөгжлийн төлөвлөгөөний талаарх асуумж, судалгааг авлаа.



Судалгааны баг ажлын үр дүнгээ ирэх 9 сард БОНХАЖЯаманд тайлагнана.

Хангайн нуруу болон Хөвсгөлийн уулсын экологийн бүс нутгийн хэмжээнд хамгаалах шаардлагатай газрыг тогтоох ажлын эхний үр дүнг танилцуулах, хэлэлцүүлэх мөн цаашдын хамтын ажиллагааны талаарх “Ногоон хөгжил ба Байгаль хамгаалал” Хангай, Хөвсгөлийн бүсийн уулзалт 2015 оны 06 сарын 25-нд болж хамгаалалтын захиргааны дарга Г.Эрдэнэбилэг амжилттай оролцлоо.

KFW байгууллагын дэмжлэгээр БОНХАЖЯ-наас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд Хамгаалалтын захиргаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, дэд бүтэц болон албан контор, орчны бүсэд шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг гаргаж төслийн ерөнхий зөвлөх Г.Гансүхд /gtzgansukh@yahoo.com/ электрон хаягаар хүргүүллээ.

Байгалийн нөөц хамгаалал

БОНХАЖЯ-ны ТХНУГ-т “Орхоны хөндийн” БЦГ-ын ойн санд 2016 онд хийх ой цэвэрлэгээний ажлын саналаа (100 га талбайд 3000 м³ мод) явууллаа.

Бат-Өлзий сумын Цагаан Хайрханы хогийг хамгаалалтын захиргаа болон Могойтын амны малчны бүлэг “Экогрэн” ХХК-тай хамтран цэвэрлэлээ.



Хархорин сумын Нарийн Хүр багийн Баянголын амны малчин өрхүүд “Баянгол” ТББ байгуулан байгаль хамгаалах, нөхөн сэргээх, ойн ашиглалт модны хулгайтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боллоо. Үйл ажиллагаагаа идэвхжүүлэх зорилгоор “Орхоны хөндийн” БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэнгээс арга зүйн зөвлөгөө авлаа.



Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хангай овооны уламжлалт тахилагын ёслол Зуны дунд сарын шинийн 3-н буюу 2015 оны 06 сарын 19 ны өдөр боллоо. Энэ арга хэмжээнд Хамгаалалтын захиргааны хамт олон жил бүр оролцон нутгийн иргэдэд байгаль хамгаалах уламжлалд зан заншилыг танилцуулж тухайн орчны хог хаягдлыг цэвэрлүүлээ



Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт

Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу Хархорин сумын хяналтын постон дээр байнгын хяналт шалгалтыг хийж байна.



2015 оны 06 сарын 03-аас-05-ны хооронд Хамгаалалтын захиргааны даргын баталсан 39-04-078-18 дугаартай удирдамжийн дагуу Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэчимэг, Аялал жуулчлал, мэдээлэл сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Ч.Суурьтогтох нарын бүрэлдэхүүнтэй баг Бат-Өлзий сумын ТХГНутагт аялал жуулчлал эрхлэн жуулчны бааз, зочны гэр ажлуулдаг аан, иргэдэд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар Эксплор монголиа ХХК-ий Порест ланд жуулчны бааз нь хамгаалалтын горим, газар ашиглах гэрээ зөрчин үйл ажиллагаа явуулж байсан тул түр Акт тогтоон үйл ажиллагааг зогсоолоо.



Хархорин сумын цагдаагийн хэлтэстэй хамтарсан шалгалтаар Улаанбаатар хотын иргэн Д.Эрдэнэдалай нь Архангай аймгийн Цэнхэр сумын Тамирын голоос 18 ширхэг Монгол хадран загас барьсан зөрчил илэрсэн тул 384000 төгрөгийн торгууль, 180000 төгрөгийн нөхөн төлбөр ноогдуулан захиргааны арга хэмжээ авлаа.

ТХНУГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндийн БЦГ, Их богдын БЦГ-ууд хамтран Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Тонгорогын даваа, Архангай аймгийн Цэнхэр сум, Өлийн даваа, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын зүүн хойд хэсэг, Хангай нурууны орчимд нутаглах айл өрхүүдээр орж хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, бууруулах, хяналт сурталчилгааны ажлыг 2015 оны 06 сарын 24-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.



Шалгалтаар ноцтой зөрчил илгээгүй бөгөөд хууль бус мод бэлтгэлийн улмаас эрүү үүсгэн шалгагдаж байгаа иргэнтэй уулзаж хэрэг бүртгэл аль шатандаа явж байгаа талаар тодруулж цаашид хэрэг зөрчил гаргахгүй байх талаар иргэдтэй харилцан тохиролцлоо.

Аялал жуулчлал, газар ашиглалт

Хүрхрээ бүсийн аялал жуулчлал эрхлэгч бүлэг нөхөрлөлийн гишүүдтэй уулзан хуралдаж энэ онд ажил үйлчилгээ явуулах газрыг заан гэрээ хийж хариуцуулж өглөө.



2015.06.19-21-нд "Мишээл экспо төв"-д зохион байгуулагдсан Үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнд "Орхоны хөндийн" БЦГ-ын хамгаалалтын захиргаа оролцлоо.



Үзэсгэлэнгийн үеэр УТХГН-ын талаарх мэдээ мэдээллийг 250 гаруй монгол аялагчдад танилцуулж сурталчилгаа хийлээ.

Улаанбаатар аялал жуулчлалын холбооноос аймгуудын БОАЖГазар, ТХГНутгийн хамгаалалтын захиргаадын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэнүүдэд зориулан аялал жуулчлалын сургалтыг Нийслэлийн аялал жуулчлалын газарт зохион байгууллаа.



Сургалтанд хамгаалалтын захиргааны аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Ч.Суурьтогтох оролцсон. Сургалтын үеэр Нийслэлийн аялал жуулчлалын газар БНХАУ-ын Хөх хоттой аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Хамгаалалтын захиргаа аялал жуулчлалын туроператорын үйл ажиллагаа эрхэлдэг Цолмон трэвэл ХХК, Нью жуулчин ХХК-уудтай ТХГНутагт нэвтрэх аялагчдаас түр нэвтрэх тасалбарын хураамжийг ваучераар тооцож байхаар гэрээ байгууллаа.

<p>Батлав: "ОРХОНЫ ХӨНДИЙН ГЭД"-ийн ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Т.ЭРДЭНОВАЛЭГ</p> <p>ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ХУРААМЖИЙГ ВАУЧЕРЫН НӨХЦӨЛӨӨР ТӨЛӨХ ТУХАЙ ГЭРЭЭ</p> <p>Хархорин Дугаар _____ ӨМ _____ оны _____</p> <p>Мангил Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6.2.2, 11.6, 17.1, 27.7, Аялал жуулчлалын тухай хуулийн 2.3-р зүйл зөвтгө, Байгаль орчны сайдын 2002.06.01 өдрийн 117 тоот тушаалыг үндэслэн Мангил Улсын Иргэний хуулийн 476, 477, 480 дугаар заалтын дагуу</p> <p>Нэг талаас БОХООЛамны харьяа Орхоны нэгдлийн байгалийн эргэлдэрт газрын хамгаалалтын захиргааны аялал жуулчлалын асуудал харуулан нэгдэмтээн Ч.Суурьтогтох, нөгөө талаас "Цолмон Турисм" Аялал жуулчлалын компанийн Борлуулалтын ажилтан... С.Н.ЭЛМЭГ нар тодорилцан, нэгдсэн хуралынхныг залуучийн системээр төлөх гэрээ нэг жилийн хугацаагаар байгуулав.</p> <p>Нэг. Нийтлэг үндэслэл</p> <p>1.1 Орхоны нэгдлийн ГЭД-ийн эвчлэвэгдсэн бусад нэгдсэн аялал жуулчлалын үйл ажиллагаа ярихад өөрсдийнхний өндөрлөгөөр төлөхөд гэрээний хэрэгжээ оршино.</p> <p>1.2 Талууд гэрээний нөхцөлийг тодорилцан, хэрэгжлээг нь хангуулах чиглэлээр өмнөх асуудлыг шийдвэрлэхэд төр хувийн хэвшлийн хэрэгжлээг гүүдэгтэн хамтран ажиллаж болно.</p> <p>Хоёр. Хамгаалалтын захиргааны зүгээс үүрэг</p> <p>2.1 Тусгай хамгаалалттай газар нутагт ТХГНГ ажиллах баримтлан дүрэм, журам болон тухайн газар нутгийн хамгаалах үнэт зүйлс, байгалийн нөөц, байгаа, аялал жуулчлалын тогтоосон амьнгалын талаарх мэдээллээр хангана.</p> <p>2.2 Аялагч жуулчдын асуутгүй байдлыг хангах зорилгоор шийдвэрлээтэй зөв хөргүй тэмдэглүүлэх, орон нутгийн захиргаатай хамтран ажлаарх асуудлыг шийдүүлнэ.</p> <p>2.3 Нэвтрэх хуралынхний орлогын тэдэрсийг хувийг аялал жуулчлалын дэд бүтэц, асуутгүй байдлыг хангахад ариуулах асуудлыг шийдвэрлэх байгууллагуудтай хамтран ажлаархуулна.</p> <p>2.4 ГЭД-г зорчсон жуулчдын тос, нэвтрэн орсон өмнөх залуучийн нэгдэмтээн хуудалд байгаа, жуулчдын эвлэлээр гарын үсэг зуруулна.</p>	<p>Батлав: "ОРХОНЫ ХӨНДИЙН ГЭД"-ийн ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Т.ЭРДЭНОВАЛЭГ</p> <p>ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ХУРААМЖИЙГ ВАУЧЕРЫН НӨХЦӨЛӨӨР ТӨЛӨХ ТУХАЙ ГЭРЭЭ</p> <p>Хархорин Дугаар _____ ӨМ _____ оны _____</p> <p>Мангил Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6.2.2, 11.6, 17.1, 27.7, Аялал жуулчлалын тухай хуулийн 2.3-р зүйл зөвтгө, Байгаль орчны сайдын 2002.06.01 өдрийн 117 тоот тушаалыг үндэслэн Мангил Улсын Иргэний хуулийн 476, 477, 480 дугаар заалтын дагуу</p> <p>Нэг талаас БОХООЛамны харьяа Орхоны нэгдлийн байгалийн эргэлдэрт газрын хамгаалалтын захиргааны аялал жуулчлалын асуудал харуулан нэгдэмтээн Ч.Суурьтогтох, нөгөө талаас "Цолмон Турисм" Аялал жуулчлалын компанийн Борлуулалтын ажилтан... С.Н.ЭЛМЭГ нар тодорилцан, нэгдсэн хуралынхныг залуучийн системээр төлөх гэрээ нэг жилийн хугацаагаар байгуулав.</p> <p>Нэг. Нийтлэг үндэслэл</p> <p>1.1 Орхоны нэгдлийн ГЭД-ийн эвчлэвэгдсэн бусад нэгдсэн аялал жуулчлалын үйл ажиллагаа ярихад өөрсдийнхний өндөрлөгөөр төлөхөд гэрээний хэрэгжээ оршино.</p> <p>1.2 Талууд гэрээний нөхцөлийг тодорилцан, хэрэгжлээг нь хангуулах чиглэлээр өмнөх асуудлыг шийдвэрлэхэд төр хувийн хэвшлийн хэрэгжлээг гүүдэгтэн хамтран ажиллаж болно.</p> <p>Хоёр. Хамгаалалтын захиргааны зүгээс үүрэг</p> <p>2.1 Тусгай хамгаалалттай газар нутагт ТХГНГ ажиллах баримтлан дүрэм, журам болон тухайн газар нутгийн хамгаалах үнэт зүйлс, байгалийн нөөц, байгаа, аялал жуулчлалын тогтоосон амьнгалын талаарх мэдээллээр хангана.</p> <p>2.2 Аялагч жуулчдын асуутгүй байдлыг хангах зорилгоор шийдвэрлээтэй зөв хөргүй тэмдэглүүлэх, орон нутгийн захиргаатай хамтран ажлаарх асуудлыг шийдүүлнэ.</p> <p>2.3 Нэвтрэх хуралынхний орлогын тэдэрсийг хувийг аялал жуулчлалын дэд бүтэц, асуутгүй байдлыг хангахад ариуулах асуудлыг шийдвэрлэх байгууллагуудтай хамтран ажлаархуулна.</p> <p>2.4 ГЭД-г зорчсон жуулчдын тос, нэвтрэн орсон өмнөх залуучийн нэгдэмтээн хуудалд байгаа, жуулчдын эвлэлээр гарын үсэг зуруулна.</p>
---	---

Ийнхүү гэрээ байгуулсанаар төр хувийн хэвшлийн итгэлцэл, хамтын ажиллагаа илүү батжиж байгаа бөгөөд ТХГНутаг дахь хариуцлагатай аялал жуулчлалыг эрх зүйн хүрээнд баталгаажуулж байгаа юм.

Хархорин сумын ОХБЦГазарт ажиллаж байгаа жуулчны баазуудын үйл ажиллагаатай танилцан цаашид нэгдсэн маршрутаас гадуур салаа зам гаргахгүй байх, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах талаар анхааруулга санамж өглөө.

Мэдээлэл, сургалт сурталчилгаа

Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтан Байгаль орчны сэдэвт Орхон бүсийн илтгэлийн уралдааныг явуулан шилдэг илтгэлүүдээ шалгарууллаа.

Үүнд: 1- байр Энэрэл / ОЦС-ын 11-р анги Хархорин сум/

2- байр Наянжин / ГСЕБС-ын 11-р анги Хархорин сум/

3-р байр Ганцэцэг / Хашаат сум 11-р анги/

4-р байр Бадамгарав / 2-р 10-н жил Хархорин сум/

5-р байр Байгаль / 2-р 10-н жил Хархорин сум/

Шилдэг багшийн шагналыг Баярцэцэг / 2-р 10-н жил Хархорин сум/ тус тус хүртлээ.



Дэлхийн байгаль хамгаалах өдрөөр Бат-Өлзий сумын эко клубын хүүхдүүд Хархорин сум болон Хамгаалалтын захиргаагаар зочиллоо.



Хамгаалалтын захиргааны албан хаагчид эко клубын хүүхдүүдээ Хархорин сумаар аялуулан, 2 музейг үнэ төлбөргүй үзүүлэн цогцолборт газар болон хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцууллаа.

Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалах үнэт зүйлс, менежментийн онцлогыг харуулсан олон нийтэд зориулсан танин мэдэхүйн баримтат киног бүтээхээр найруулагч Д.Сумхүүтэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, маршрутыг гаргалаа. Кино бүтэхэд шаардагдах төсвийг НҮБ-ийн ТХГНСБ нь төслөөс дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа юм.

Мөн төслийн хөрөнгө оруулалтаар Орхоны хөндийн ТХГНутагт байгаль хамгааллын үйл ажиллагаа явуулдаг бүлэг нөхөрлөлүүдийн хүрээнд жөндөрийн тэгш оролцооны талаарх сургалтыг Хүрхрээ бүсэд зохион байгууллаа.



Сургалтанд Хархорин, Хужирт, Уянга, Батэлзий сумдын 6 нөхөрлөлийн 22 гишүүн хамрагдлаа.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.